



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2021 оны 09 сарын 24 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс
урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, холбогдох журмын хэрэгжилтийг хангах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.1.8, 6.1.14 дэх заалт, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.2, 7.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ДААЛГАХ нь:

1. Төв, орон нутгийн нэгжийн дарга нарт:

1.1.Нэгжийн дарга нар өөрийн болон харьяалах нэгжийн мэдүүлэг гаргагч, төрийн захиргааны албан хаагчид (цаашид мэдүүлэг гаргагч гэх)-ыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 04 дүгээр хавсралтаар баталсан “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг маягтын дагуу тухай бүр мэдүүлж, хяналт, шалгалт хийх, үнэлгээний баг, хороонд ажиллах, захиргааны шийдвэр гаргах, гэрээ байгуулах, тэдгээрийг бэлтгэх, оролцохын өмнө ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухайгаа тохиолдол бүрд мэдүүлж, Захиргаа, удирдлагын газрын эрх бүхий албан тушаалтан (хүний нөөц, сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн), орон нутаг дахь газрын салбар эрх бүхий албан тушаалтан (захиргааны ахлах мэргэжилтэн)-д сар бүрийн 30-ны өдрийн дотор өгч, цахим системд бүртгүүлж байх;

1.2.Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, холбогдох журмын хэрэгжилтийг хангах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнд хүргэх, хэрэгжилтэд хяналт тавих;

1.3.Төсвийн шууд захирагч нар байгууллагын даргын тушаалаар томилогдсон салбар эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлж ажиллах.

00000041

2.Эрх бүхий албан тушаалтнуудад:

2.1.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн үйлчлэлд хамаарах төрийн захиргааны дэс түшмэлийн ангиллын ТЗ-6, төрийн үйлчилгээний ТҮ-8 ба түүнээс зэрэглэлээр цалинждаг, мэдүүлэг гаргагч албан хаагчдын хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ томилогдсон өдрөөс хойш 30 хоног, тайлант хугацаанд мэдүүлсний дараа хөрөнгө, орлого нь их хэмжээний өөрчлөлт орсон тохиолдолд 30 хоногийн дотор, цаашид жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргуулж, Авлигатай тэмцэх газрын "Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим систем" (цаашид цахим систем гэх)-д бүртгэх;

2.2.Мэдүүлэг гаргагч албан хаагчийн шилжин болон сэлгэн ажиллах, шинээр төрийн жинхэнэ албан хаагчаар томилогдохоос өмнө ХАСУМ буюу хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн хийх эрхийг цахим системд нээж, хяналт тавих;

2.3.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д "албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, тэдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана" гэж заасны дагуу ашиг сонирхлын зөрчлийг мэдэгдэх, тайлбарлах үйл ажиллагааг хэрэгжүүлж хэвших, цахим системд тухай бүр бүртгэлийг оруулах;

2.4.Авлигатай тэмцэх газрын цахим сайт, Legalinfo.mn хуулийн цахим сангаас холбогдох хууль тогтоомжийг судалж, албан хэргийн мэдлэгээ байнга дээшлүүлж, орон нутаг дахь нэгжийн хэмжээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг сурталчлах, албан хаагчдыг мэдээллээр хангах сургалт, мэдээллийн ажлыг тогтмолжуулах;

2.5.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, Гадаадын иргэн, харьяатын газраас авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, тайланг жил бүрийн 06, 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор цаасаар болон цахимаар Захиргаа, удирдлагын газарт ирүүлэх;

2.6.Цахим системд эрх бүхий албан тушаалтнаас тухай бүр хөтлөх хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн, ХАСХОМ хүлээн авсан тухай, мэдэгдэл, тайлбар тэдгээрийн шийдвэрлэлтийн зэрэг бүртгэлийг бүрэн хөтөлж, жил бүрийн 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор нэгжийн тайланг ирүүлж байх;

2.7.Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх үндэслэл бүхий мэдээ, мэдээллийг байгууллагын удирдлагад тухай бүр, шуурхай мэдээлэх.

3. Мэдүүлэг гаргагчдад:


3.1. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн үйлчлэлд хамаарах төрийн захиргааны дэс түшмэлийн ангиллын ТЗ-6 ба түүнээс дээш зэрэглэлээр цалинждаг, мэдүүлэг гаргагчдад дээрх хууль тогтоомж, бусад холбогдох дүрэм, журмыг сайтар судалж, үйл ажиллагааны хэрэглээ болгож, хууль тогтоомж зөрчсөнөөс үүсэх хариуцлага, сөрөг үр дагаврыг онцгой анхаарч, өөрийгөө эрсдэлээс хамгаалах;

3.2. Мэдүүлэг гаргагч нь хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргах, тайлант хугацаанд мэдүүлгээ мэдүүлсний дараа хөрөнгө, орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 250 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу 105 сая төгрөг, түүнээс дээш хэмжээгээр өөрчлөгдсөнийг 30 хоногийн дотор мэдүүлж байх;

3.3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан хориглолт (албаны мэдээллийг ашиглах, оффшор бүсэд данс эзэмших, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө эзэмших, хуулийн этгээд байгуулах), 11-22 дугаар зүйлд заасан албан үүргээ гүйцэтгэх, шийдвэр гаргахад нөлөөлөх, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой хориглолт, сурталчилгаа, төлөөлөл, бусад орлого, төлбөр авах, бэлэг, хандив авах, давхар ажил эрхлэхтэй холбоотой хязгаарлалтуудыг мөрдөж, зөрчилгүй ажиллах.

4. Албан даалгаврын холбогдох заалтыг зөрчсөн албан тушаалтанд хууль, журмын дагуу сахилгын арга хэмжээ авах саналыг танилцуулж, шийдвэрлүүлэхийг төв, орон нутгийн нэгжийн дарга нарт даалгасугай.

5. Албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг газар, хэлтсийн хэмжээнд зохион байгуулж, биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнаж байхыг төв, орон нутгийн нэгжийн дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газрын хүний нөөц, сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн (В.Шоовдор)-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА  Н.УУГАНБАЯР